



ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжид 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан цаглабарын дагуу Засгийн газар жилийн төсвийн төслийг боловсруулж, 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлахаар заасан.

Харин Улсын Их Хурал Улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хууль тогтоомжид заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газраас төсвийн төслийг дахин боловсруулж, өргөн мэдүүлж, батлах тусгайлсан зохицуулалт байхгүй байна.

Энэ нь Засгийн газар төсвийг боловсруулж, өргөн мэдүүлэхэд баримтлах төсвийн цаглабар болон төсвийн төсөлд хийх олон нийтийн хэлэлцүүлгийн зохицуулалтад өөрчлөлт оруулах эрх зүйн үндэслэл болж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

1 дүгээр зүйлд Улсын Их Хурал улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хууль тогтоомжид заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газраас төсвийн төслийг дахин боловсруулж, өргөн мэдүүлж, батлах тусгайлсан зохицуулалтыг тусгана.

Мөн дээрх нөхцөл байдал үүссэн тохиолдолд Улсын Их Хуралд дахин өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсэг, мөн хуулийн 28¹ дүгээр зүйл хамаарахгүй байх, Төсвийн тухай хуулийн 8.4.5-д заасны дагуу өргөн мэдүүлсэн хүрээнд боловсруулсан төсвийн танилцуулга, тооцоолол, судалгаанд үндэслэн холбогдох өөрчлөлтийг тусгаж, нэгдсэн төсвийн нийт зарлага болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэлгүй дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэн батлах зохицуулалтыг тусгана.

2 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг заана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Улсын Их Хурал Улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хууль тогтоомжид заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газраас төсвийн төслийг боловсруулж, дахин өргөн мэдүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай бүрэн нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.